

Ректорын 2006 оны 06 сарын ... ны
114 тоот тушаалын 1-р хавсралт

Профессор, багш нарын бүтээлийн жагсаалт бичих заавар

1. Багш нарын бүтээл нь БСШУЯ-с 2003 онд батлагдсан номын сангийн ном зүйн бичилт хийх дараахь үндсэн стандартын дагуу бичигдэнэ. Үүнд:
 Толгой гарчиг: /Зохиогчийн нэр, овгийн эхний үсэг цэг/
 Үндсэн гарчиг: /Гарчигт хамааралтай бусад мэдээнүүд/
 Оролцогчдын тухай эхний мэдээнүүд; Оролцогчдын тухай дархь мэдээнүүд.
 Хэвлэлийн тухай мэдээнүүд.-Хэвлэгдсэн газар: Хэвлэлийн газар, Хэвлэгдсэн он. -Хуудасны тоо.-
 /ISBN.- Үнэ.
 Жишээ нь:
 Сэргээ Ж.
 Монголчуудын номын өв.-/ Ред. С.Цэцэгмаа, Ч. Алтанцэцэг ба бус. -УБ: Өнгөт хэвлэл, 2003.-76x.-ISBN 99929-5-110-9. -8000төг.
2. Мөн бүтээлийн жагсаалтын нүүрэн талд харьяалагдах сургууль, тэнхим, профессорын баг болон овог нэр, эрдмийн цол зэрэг алдрыг бүрэн бичих шаардлагатай.
3. Профессор, багш нар нь бүтээлийн жагсаалтаа бичихдээ бүтээлээ :
 Нэг. Эрдмийн зэрэг хамгаалсан сэдэв. Үүнд : Хаана, хэдэн онд, ямар хэл дээр зэргийг бичнэ.
 Хоёр. Нэг сэдэвт бүтээл
 Гурав. Сурах бичиг, гарын авлага
 Дөрөв. Эрдэм шинжилгээний өгүүллүүд
 Тав. Үйлдвэрлэл, практикт шилжүүлсэн бүтээл
 Зургаа. Орчуулга гэсэн 6 бүлэгт хувааж, дотор нь, бичсэн он дарааллын дагуу ангилж бичнэ.
4. Жагсаалтыг бичихдээ 2 хэлбэрээр :
 а/ File-p (Arial Mon,)
 б/ Бичгийн цаасан дээр гаргаж ирүүлнэ.
5. Материалын 2006 оны 09-р сарын 15-аас өмнө холбогдох эрдэмтэн нарийн бичгийн дарга наарт бүрдүүлж өгнө.